



Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын Байнгын хорооны
хүсэлтээр хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

**ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХАМРАХ ХҮРЭЭГ
НЭМЭГДҮҮЛЭХ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН
ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙГ ШИНЭЧЛЭХ
ШААРДЛАГАТАЙ БАЙНА.**

**ТАХИР ДУТУУ ИРГЭДИЙН
МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, СЭРГЭЭН
ЗАСАЛТЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
2004 ОНЫ ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН
ЗАРЦУУЛАЛТ, САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ**

Улаанбаатар хот

2005 оны 4 дүгээр сар

Агуулга

Ерөнхий зүйл	Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	3
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3
	Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд	4
	Аудитын стандартын талаархи мэдэгдэл	4
Аудитын дүн	ТДИМССЗҮТ-ийн 2004 оны үйл ажиллагааны чиглэл, зорилтын биелэлт	5
	ТДИМССЗҮТ-ийн 2004 оны санхүүжилтийн эх үүсвэрийн төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалт, санхүүгийн тайлагнал	8
	ТДИТССЗҮТ-ийн үйл ажиллагаанд хяналт, шалгалтын байгууллагуудаас хийгдсэн шалгалтын дүн, хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн	10
Дүгнэлт		13
Холбогдох байгууллагын санал	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны санал	14
	Тахир дутуу иргэдийн мэргэжлийн сургалт, сэргээн засалтын үндэсний төвийн санал	15
Зөвлөмж		16

Товчилсон үгийн тайлбар:

ТДИМССЗҮТ	Тахир дутуу иргэдийн мэргэжлийн сургалт, сэргээн засалтын үндэсний төв
НХХЯ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
СЭЗЯ	Санхүү, эдийн засгийн яам
ҮСГ	Үндэсний статистикийн газар
ТБУСТХ	Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль
УМХГ	Улсын мэргэжлийн хяналтын газар

Ерөнхий зүйл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын Байнгын хорооны хүсэлт, Үндэсний аудитын газрын 2005 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитын зорилт:

1. Тахир дутуу иргэдийн мэргэжлийн сургалт, сэргээн засалтын үндэсний төвийн (ТДИМССЗҮТ) үйл ажиллагаа. Үүнд:

- Төвийн дүрмээр тодорхойлогдсон чиг үүрэг, зорилтыг үйл ажиллагааны төлөвлөгөө, Төсвийн Ерөнхийлөн захирагчтай байгуулсан Үр дүнгийн гэрээнд тусгасан байдал,
- Үр дүнгийн гэрээний биелэлт,
- Төвийн үйл ажиллагаатай холбоотой хөтөлбөр, шийдвэрийн хэрэгжилт,
- Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл хөтөлбөр, төвийн үйл ажиллагааны уялдаа холбоо.

2. 2004 оны санхүүжилтийн эх үүсвэрийн төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалт, тайлагнал, Үүнд:

- Төсвийн санхүүжилтийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалт,
- Үйл ажиллагааны орлогыг төлөвлөж, бүрдүүлсэн байдал,
- Санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлан.

3. ТДИМССЗҮТ-ийн үйл ажиллагаанд хяналт, шалгалтын байгууллагуудаас хийсэн шалгалтын дүн, өгсөн үүрэг даалгаврын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн, Үүнд:

- Хяналт шалгалтын байгууллагаас өгөгдсөн үүрэг даалгавар, зөвлөмж,
- Хяналт шалгалтын мөрөөр хэрэгжүүлсэн ажил,
- Байгууллагын дотоод хяналтын тогтолцоо, түүний үр нөлөө.

Аудитад ТДИМССЗҮТ-ийн санхүүгийн үндсэн баримт, материал, холбогдох байгууллагаас авсан мэдээ, судалгаанд түүвэрлэсэн байдлаар шинжилгээний болон шалгалтын нарийвчилсан арга зүй, горимыг хэрэглэв.

Ерөнхий зүйл

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд

Дараахь баримт, материалыг шалгуур болгон ашиглав.

Үүнд:

- Тахир дутуу хүний нийгмийн хамгааллын тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2000 оны 47 дугаар тушаал
- ТДИМССЗҮТ-ийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, зорилттой холбогдох бусад эрх зүйн баримт, материал

Аудитын стандартын талаархи мэдэгдэл

Гүйцэтгэлийн аудитыг хийхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журмыг баримталсан бөгөөд Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдөж, аудитын дүгнэлтэд холбогдох нотлох зүйлс, бусад мэдээллийг ажлын баримтад хавсаргав.

Аудитыг Үндэсний аудитын газрын 2 дугаар хэлтсийн Нийгмийн салбарын багийн аудитор, шинжээч нар гүйцэтгэв.

Аудитын дүн

Төвийн 2004 оны үйл ажиллагааны чиглэл, зорилтын байдал

- Төвийн дүрмээр тодорхойлогдсон чиг үүрэг, зорилтыг үйл ажиллагааны төлөвлөгөө, Төсвийн Ерөнхийлөн захирагчтай байгуулсан Үр дүнгийн гэрээнд тусгасан байдал:

Тахир дутуу иргэдийн мэргэжлийн сургалт, сэргээн засалтын үндэсний төв /Төв/ нь Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 1999 оны А/270 дугаар тушаалын дагуу шинэчлэн зохион байгуулагдан 2000 оны 9 дүгээр сарын 1-нээс Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны харъяалалд шилжжээ. НХХ-ийн сайдын 2000 оны 47 дугаар тушаалаар “Тахир дутуу иргэдийн мэргэжлийн сургалт, сэргээн засалтын үндэсний төв”-ийн дүрмийг шинэчлэн баталсан бөгөөд улсын хэмжээнд Тахир дутуу иргэдэд алдагдсан эрхтэний үйл ажиллагааг сэргээн засах, хиймэл гар, хөл болон бусад эрхтэний протез, ортопедийн хэрэгслээр үйлчлэх, мэргэжлийн боловсрол олгох, эмчилгээ, үйлчилгээг үзүүлэх үүрэг бүхий байгууллага юм.

Төв нь зохион байгуулалтын хувьд дүрэмд заасны дагуу протез, ортопедийн үйлдвэр, сургалтын тэнхим, сэргээн засах эмчилгээний тасаг, мэдээлэл, сургалт сурталчилгааны алба гэсэн үндсэн нэгжтэй, 51 орон тоотой ажиллаж байна.

2004 онд Төв нь НХХЯ-ны эрх зүйн шийдвэрт тусгагдсан арга хэмжээ, нэгжүүдийн гүйцэтгэх үүрэг, зорилтыг үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган, ТБУСТХ-ийн дагуу Төсвийн Ерөнхийлөн захирагчтай үр дүнгийн гэрээ байгуулан ажиллажээ.

Төсвийн Ерөнхийлөн захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээнд хэтийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт 11 бүтээгдэхүүн, түүний дотор Төсвийн Ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний бодлого, зорилттой уялдуулан тусгай захиалгат 4 бүтээгдэхүүнийг нийлүүлэх үүрэг оржээ.

- Үр дүнгийн гэрээний биелэлт:

Протез, ортопедийн үйлдвэр нь 1965 онд байгуулагдсан, жилд 30 гаруй нэр төрлийн 1500 гаруй протез, ортопедийн хэрэгсэл үйлдвэрлэж байна. Үйлдвэр нь байгуулагдсанаас хойш ашиглаж ирсэн техник, тоног төхөөрөмжөөр үйлдвэрлэл явуулж байгаа бөгөөд техник, технологийн шинэчлэл хийгдээгүй байна.

Тусгай захиалгат бүтээгдэхүүний хүрээнд 2004 онд 1100 хүнд үйлчлэхээс 1137 хүнд 35,4 сая төгрөгийн протез,

Аудитын дүн

ортопедийн хэрэгсэл үйлдвэрлэн үйлчилж, жилд 3-аас доошгүй аймагт явуулын үйлчилгээг хүргэх зорилгоор 7 аймагт үйлчилгээг зохион байгуулан 187 тахир дутуу хүнд үйлчилгээ үзүүлжээ.

2003-2004 оны хичээлийн жилд сургалтын тэнхим иргэдийн хөдөлмөрийн зах зээлд оролцох чадвар, бие даан амьдрах боломжийг дээшлүүлэхэд чиглэгдсэн 9 мэргэжлээр 120 хүнийг мэргэжлийн сургалтад хамруулахаас 160 оюутан элсүүлж, 151 оюутныг төгсгөн мэргэжлийн зэрэг, гэрчилгээ олгожээ.

Хөдөлмөр эрхлэлтийн судалгаагаар төгсөгчдийн 42,5 хувь нь аж ахуйн байгууллагад, 2,5 хувь нь сургуульд дэвшин суралцаж, 11,8 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлж байна.

Сэргээн засах эмчилгээний тасаг нь 2004 онд 1100 тахир дутуу хүмүүст нөхөн сэргээлтийн зөвлөгөө өгч, 490 өвчтөнг 4900 ор хоног хэвтэж эмчлүүлэхээс 522 өвчтөн хүлээн авч 5690 ор хоногийн нөхөн сэргээлтийн эмчилгээ үйлчилгээ үзүүлсний дотор 126 өвчтөн орон нутгаас, 143 өвчтөн давтан хэвтэж эмчлүүлсэн байна.

Тус тасаг нь “Аймгийн нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандарт”-аар магадлан итгэмжлэгдсэн боловч өрөө тасалгааны талбай, эмчилгээний багаж төхөөрөмж хангалтгүй байна.

2001 онд Тахир дутуу иргэдийг дэмжих жилийн хүрээнд байгуулагдсан мэдээлэл, сургалт сурталчилгааны алба нь судалгаа хийх, мэдээллийн бааз байгуулах, иргэдэд мэдээлэл, сургалт, сурталчилгаа, зөвлөгөө өгөх, төсөл боловсруулан хэрэгжүүлэх ажлыг гүйцэтгэж иржээ.

Тахир дутуу иргэдийг илрүүлэх, хэрэгцээг тодорхойлох түүвэр судалгааг 10000 хүнд хийхээс 11283 хүнд хийж, мэдээллийн санд оруулан, 1000 хүнд зөвлөгөө өгчээ.

Судалгаанд хамрагдсан тахир дутуу иргэдийн 65,1 хувь эмнэлгийн сэргээн засалт, мэргэжлийн сургалтын аль алинд нь огт хамрагдаагүй байна. Тахир дутуугийн байдлын хувьд 25,8 хувь нь хөдөлгөөний өөрчлөлттэй, 15,6 хувь нь хэл ярианы согогтой, 14,3 хувь нь харааны согогтой, 33,6 хувь нь сэтгэцийн эмгэг хавсарсан согогтой, тэдгээрийн 65,6 хувь нь хөдөлмөрийн насных байсан бөгөөд тахир дутуу хүний төрөл бүрийн тусгай хэрэгслийн хэрэгцээ зайлшгүй шаардлагатай гэсэн дүн гарч байна.

2004 онд протез, ортопедийн хэрэгслээр үйлчлүүлэгсдийн төлбөрийн 64,8 хувийг нийгмийн даатгал, халамжийн байгууллагаас, 26,5 хувийг иргэд өөрсдөө, 8,6 хувийг

Аудитын дүн

буяны болон албан байгууллагаас төлсөн байна. НХХ-ийн сайдын 2003 оны 168 дугаар тушаалын дагуу дараахь аймаг болох Дархан-Уул, Дорноговь, Орхон, Сэлэнгэ, нийслэлийн 4 дүүргийн ирүүлсэн судалгааны дүнгээр протез, ортопедийн хэрэгсэл шаардлагатай гэсэн хүмүүсийн тоо 13276, тэдгээрийн 90,5 хувь нь төлбөрөө нийгмийн даатгал, халамжийн байгууллагаас, 9,5 хувь нь хувиараа төлөхөөр гарсан байна. Бусад аймаг, нийслэлийн дүүрэг судалгаанд хамрагдаагүй байна. 2004 онд ҮСГ-аас явуулсан судалгаагаар улсын хэмжээнд 69263 тахир дутуу иргэд бүртгэгдсэний 45,0 хувь нь хотод, 55,0 хувь нь хөдөө орон нутагт байгаа гэсэн дүн гарчээ.

- Төвийн үйл ажиллагаатай холбоотой хөтөлбөр, шийдвэрийн хэрэгжилт:

Монгол Улсын Засгийн газраас 1998-2004 онд хэрэгжүүлэхээр баталсан “Тахир дутуу иргэдийн аж байдлыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийн төвтэй холбогдох заалтыг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт 2004 оны төсвийн төлөвлөгөөнд тусгагдаагүй боловч сэргээн засалтын зөвлөгөө өгөх, орон нутагт тусламж үйлчилгээ үзүүлэх, протез ортопедийн засварын цех байгуулах, засварчинг бэлтгэх, нийгмийн халамжийн болон нөхөн сэргээлтийн сайн дурын идэвхтэн бэлтгэх, сургалтын төрлийг өргөжүүлэх, материаллаг баазыг бэхжүүлэх, тахир дутуу иргэдийн амьдрал ахуйд зориулсан зөвлөмж боловсруулан тараах ажлыг хийж ирсэн байна.

- Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл хөтөлбөр, төвийн үйл ажиллагааны үялдаа холбоо

Тус Төвд Итали улсын АИФО /Засгийн газрын бус/ байгууллагын санхүүжилттэй “Тэгш дүүрэн” хөтөлбөр хэрэгжиж байна. Хөтөлбөр нь тахир дутуу хүмүүст нийгмийн бүхий л салбарын үйлчилгээг хүргэх, ойртуулах, хүртээмжтэй болгоход тахир дутуу иргэд, тэдний гэр бүл, нийгэм, хамт олны оролцоог өрнүүлэх, тахир дутуу хүмүүст хандах нийгмийн сэтгэлгээг эерэг болгох, иргэний эрхийг хамгаалах зорилготой байна. Хөтөлбөр нь АИФО-ийн Монгол улс дахь суурин төлөөлөгчийн газар, Эрүүл мэндийн яамны ерөнхий удирдлага дор нийтдээ 12 аймаг, Улаанбаатар хотын 6 дүүрэгт Төсөл хэрэгжүүлэх үндэсний баг, аймаг, сумдын салбар хороодоор

Аудитын дүн

дамжуулан үйл ажиллагаагаа явуулж байна. 2004 онд хөтөлбөрийн хэрэгжилтэд нийт 51,2 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч тахир дутуу иргэдийг сэргээн засах чиглэлээр нийслэл, аймаг, дүүргийн өрхийн болон багийн эмч нарт зориулсан сургалт, тахир дутуу иргэдтэй ажиллах, тэдэнд туслах сайн дурын ажилтнуудын болон эцэг эхчүүдэд зориулсан сургалт зохион байгуулж, тахир дутуу иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, амьжиргааны түвшинг дээшлүүлэх зээлийн эргэлтийн сангийн мэргэжилтнүүд, дүүргийн нийгмийн ажилтныг сургах, тахир дутуу иргэдийн төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжих, хамтран ажиллах зэргээр тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа нь төвийн дүрмээр тодорхойлогдсон чиг үүрэгт нийцэж байна. АИФО байгууллагаас зээлийн эргэлтийн санд нийт 3 удаагийн санхүүжилтээр 60,6 мянган ам.долларыг хуваарилсан бөгөөд төслийн хэрэгжилтийн хугацаанд 526 жижиг төслийг санхүүжүүлж, төсөлд тахир дутуу иргэд, тэдний гэр бүлийн 2600 гаруй иргэд хамрагджээ. Төв нь төслийн хүрээнд гадаадын байгууллагатай мэдээлэл солилцож, мэргэжилтэн давтан сургасан, танилцах семинарт хамруулсны зэрэгцээ гадаадын мэргэжилтнийг урьж ажиллуулсан байна. Цаашид шинэ технологи нэвтрүүлэх, үйлдвэрийн ажилтнуудыг сургалтад хамруулах, тоног төхөөрөмжөө шинэчлэх бололцоог эрж хайх талаар шуурхай ажиллах шаардлагатай байна.

Төвийн 2004 оны санхүүжилтийн эх үүсвэрийн төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалт, тайлагнал

- Төсвийн санхүүжилтийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалт:

СЭЗЯ-наас Төвийн 2004 оны үйл ажиллагааны зардлын санхүүжилтийг төсвөөс 111,1 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 10,8 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 34,0 сая төгрөг, нийт 155,9 сая төгрөгийн санхүүжилттэй ажиллахаар баталжээ.

2004 оны орлого, санхүүжилтийн гүйцэтгэлийг авч үзэхэд төсвийн санхүүжилт 23,3 сая төгрөгөөр дутуу буюу 79,0 хувиар санхүүжсэн, эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 10,6 сая төгрөг буюу 98,6 хувиар санхүүжсэн, үндсэн үйл ажиллагааны орлого төлөвлөснөөс 51,1 сая төгрөгөөр буюу 150,5 хувиар өсч, батлагдсан төсвийн гүйцэтгэл 95,9 хувь буюу нийт 153,1 сая төгрөгийн эх үүсвэрээр үйл ажиллагаагаа явуулжээ.

Аудитын дүн

2004 оны үндсэн үйл ажиллагааны нийт зардлын 45,6 хувь буюу 70,4 сая төгрөгийг ажиллагсадтай холбоотой зардал, 51,2 хувь буюу 79,1 сая төгрөгийг бараа, үйлчилгээний зардал эзэлж байна.

Зардлын гүйцэтгэлийн хувьд бараа үйлчилгээний зардал болох байрны халаалт, цахилгаан, усны, албан томилолтын, зөөлөн эдлэл худалдан авах зэрэг зардлыг 9426,9 мянган төгрөгөөр хэмнэсэн боловч эмийн болон төлбөр хураамжийн зардал 3614,8 мянган төгрөгөөр хэтэрсэн нь протезийн туслах материалын импортын үнийн өсөлт, тээврийн зардлаас шалтгаалжээ.

- Өөрийн үйл ажиллагааны орлогыг төлөвлөж, бүрдүүлсэн байдал:

Төвийн 2004 оны үндсэн үйл ажиллагааны орлогоор нийт 51,1 сая төгрөг төвлөрүүлсэн ба бүтцийн хувьд 82,3 хувийг протез ортопедийн хэрэгслийг үйлдвэрлэж, үйлчилсний төлбөрт орлогоос, 17,7 хувийг сургалтын орлого болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан бусад эх үүсвэрээс төвлөрүүлсэн ба орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлж, бүртгэлд тусгасан байна.

Төв нь орон нутгийн нийгмийн халамж, үйлчилгээний төвтэй хамтран судалгаа явуулж, түүний үндсэн дээр протез, ортопедийн хэрэгсэл үйлдвэрлэж иргэдэд үйлчилсэн, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сантай хамтран тахир дутуу иргэдэд мэргэжлийн чиг баримжаа олгох чиглэлээр сургалт зохион байгуулсан зэрэг нь өөрийн орлогыг нэмэгдүүлэхэд нөлөөлжээ.

- Санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлагнал

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, байгууллагын эд хөрөнгөд нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтын журмыг гарган мөрдөж ажиллажээ. 2003 онд “Тахир дутуу иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх төсөл”-өөс сургалтын баазыг бэхжүүлэхэд нийлүүлэгдсэн 11 ширхэг компьютерийг бүртгэлд тусгаагүй байна.

Аудитын төлөвлөгөөний дагуу бид 2004 оны санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт гарган тайланг хүргүүлсэн болно.

Аудитаар үндсэн бус үйл ажиллагааны орлого, зарлагыг дутуу илэрхийлсэн, төрийн сангийн харилцах дансны үлдэгдлийг авлагаар бүртгээгүй, хөрөнгийн орлогыг

Аудитын дүн

бүртгэлд тусгаагүй зэрэг 83,1 сая төгрөгийн алдаа илрүүлж, санхүүгийн тайланд залруулан тусгаж, Төвийн эд хөрөнгөд нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг сайжруулахыг зөвлөмж болголоо.

Төвийн үйл ажиллагаанд хяналт, шалгалтын байгууллагуудаас хийгдсэн шалгалтын дүн, хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн

- Хяналт шалгалтын байгууллагуудаас өгөгдсөн үүрэг даалгавар, зөвлөмж:

2003-2004 онд Төвд НХХЯ-ны мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газраас мониторинг үнэлгээний, Улсын мэргэжлийн хяналтын газар, Нийслэл, дүүргийн татварын хэлтэс, Нийгмийн даатгалын газраас тодорхой чиглэлээр шалгалт хийгдсэн байна.

2004 оны Нийгмийн даатгалын хэлтсийн шалгалтаар нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалт, төлөлтийн талаар зөрчил илрээгүй байна.

2003 оны Татварын газрын татвар ногдуулалт, төлөлтийн байдалд хийсэн ээлжит шалгалтаар 674,2 мянган төгрөгийн нөхөн татвар ногдуулжээ.

УМХГ-аас 2003 онд төвийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар төрийн өмчийг түрээслүүлсний орлогын 20 хувь болох 275,0 мянган төгрөг, хүн амын орлогын албан татварыг суутгаж төсөвт шилжүүлээгүй 510,0 мянган төгрөгийн зөрчил гарч акт тогтоогдсон байна.

Шалгалтаар илэрч тогтоогдсон зөрчлийг төлбөрийн актын дагуу бүрэн барагдуулжээ.

УМХГ-аас 2004 онд хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд хийсэн шалгалтаар тус төвийн үйл ажиллагаанд хөдөлмөрийн аюулгүй үйл ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангаагүй, эмнэлгийн зориулалтын байргүй, сургалт, үйлдвэрлэлийн нөхцөл муу, хөдөлмөрийн сахилга хариуцлага сул, барилгын өргөтгөлийн зураг, төслийг мэргэжлийн байгууллагаар хянуулаагүй, газрын зөвшөөрөл аваагүй, протез, ортопедийн хэрэгслийн үйлдвэрлэл эрхлэх журам заавар, стандартгүй, хөдөлмөрийн тухай хуулийн зарим заалт хэрэгжихгүй байна гэсэн дүгнэлт өгч, барилгын ажлын гүйцэтгэлийг хянуулах, эмнэлгийн зориулалтын байртай болох, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлыг зохицуулах эрх зүйн актуудыг шинэчлэх, бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох талаар зөвлөмж өгсөн байна.

НХХЯ-наас хийгдсэн мониторинг үнэлгээ, мэдээллийн шалгалтаар төвийн үндсэн үйл ажиллагааны төлөвлөгөө, 2004 онд төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилтийг III улирлын байдлаар “хангалттай” биелэгдсэн гэж дүгнэжээ.

Уг шалгалтаар цаашид ажилтнуудын хариуцлагыг дээшлүүлэх, дотоод хяналтын үр нөлөөтэй тогтолцоог бүрдүүлэх, төвийн үйл ажиллагааг аймаг, нийслэлийн хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний төвүүдийн ажилтай уялдуулах, өмч хөрөнгийн хамгаалалтыг сайжруулах, протез, ортопедийн үйлдвэрлэлд инженерийн боловсон хүчин, мэргэжилтэй ажилтны нөөцийг бэлтгэх, тоног төхөөрөмжийг шинэчлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлж, үр дүнг танилцуулах, байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгон хөгжүүлэх саналаа боловсруулан шийдвэрлүүлэхийг үүрэг болгожээ.

- Хяналт шалгалтын мөрөөр хэрэгжүүлсэн ажил:

НХХЯ болон бусад байгууллагын шалгалтаар дотоод зохион байгуулалт, үйл ажиллагаанд илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаар Төвийн удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэн төлөвлөгөө гарган ажиллаж, үйл ажиллагааны орлого, оюутны байрны зардлаас 3526,3 мянган төгрөгийн тохижилтын ажлыг хийж, дотоод журам, хөдөлмөрийн гэрээг шинэчилж, үйл ажиллагаандаа хяналт-шинжилгээ үнэлгээ хийн, тайланг хүргүүлэх арга хэмжээг авч, ажилчдын ажлын хариуцлага, сахилга, ажлын цаг ашиглалтад хяналт тавих сар бүрийн төлөвлөгөөг мөрдөхийн зэрэгцээ төвөөс гаргах мэдээ, тайлангийн журмыг шинэчилж батлан ажиллажээ.

Төвийн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, байгууллагыг хөгжүүлэх талаар өгөгдсөн үүргийн хэрэгжилт эргэн тайлагнах шатанд байгаа бөгөөд уг асуудлыг НХХС-ын стратегийн баримт бичигт давхар тусгагдсан учраас НХХЯ-ны бодитой дэмжлэгт тулгуурлан хугацаанд нь хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Мөн УМХГ-аас хийгдсэн шалгалтын дүгнэлт, саналууд нь төвийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх, хугацаа, хөрөнгө оруулалт шаардагдах арга хэмжээ тул хэрэгжилтийг мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор гүйцэтгэх шаардлагатай юм.

Аудитын дүн

- Байгууллагын дотоод хяналтын тогтолцоо, түүний үр нөлөө:

НХХ-ийн сайдын 2001 оны 24 дүгээр тушаалаар баталсан протез, ортопедийн хэрэгслэлийн жишиг үнийг баримтлан үйлчилгээг үзүүлж, элсэлтийн журам, батлагдсан сургалтын хөтөлбөр, чиглэлийн дагуу суралцагсдыг элсүүлэн, сургалтыг явуулж байна.

Төвийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналтыг сайжруулах санамж бичгийг гарган, нэгжүүдийн удирдлага үйл ажиллагаандаа хяналт тавих үүрэг хүлээж, бүтээгдэхүүний орц, нормыг тогтоох, шинэ бүтээгдэхүүнд зураг авалт хийх, үйлдвэрлэл, эмчилгээ, сургалтад олгогдсон материал, түүхий эд, эмийн зарцуулалтыг санхүүтэй тооцоо нийлж тайланг захирлын зөвлөлөөрөө хэлэлцэж иржээ.

Эмийн хэрэгцээ, захиалгыг “Монос Фарм” ХХК-аас гэрээгээр, үйлдвэрлэл, сургалтад шаардагдах зарим туслах түүхий эд, материалыг дотоодын зах зээл, хувь хүмүүсээс үйлдвэрлэл эрхэлсэн менежер, мастер, багш, аж ахуйн нярав нарын бүрэлдэхүүнтэйгээр худалдан авч байна.

2004-2005 оны хичээлийн жилээс багш нарт сургалтын хөтөлбөрт тусгагдсан дадлагын хичээлийг явуулах материалыг бэлтгэхэд зориулан эргэн төлөгдөх нөхцлөөр гэрээ байгуулан, бэлэн мөнгө олгон ажиллаж эхэлжээ. Улирал бүр эд хариуцагчаас бүтээгдэхүүн болон бараа, материалын тайланг авч нягтлан бодох бүртгэлтэй тулган, үлдэгдлийг баталгаажуулдаг ба аудитаар үйлдвэрлэл, эмчилгээний тасагт олгосон материал, захиалгат бүтээгдэхүүн, эмийн зарцуулалт, бүртгэлээр байгаа бараа материалын үлдэгдлийг тоолж шалгахад дутагдал, зөрчил гараагүй болно.

Холбогдох байгууллагын санал

Нийгмийн хамгаалал,
хөдөлмөрийн яамны
санал


**МОНГОЛ УЛСЫН НИЙГМИЙН
ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН ЯАМ**
210646 Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг, Нэгдсэн үндэсний гудамж 5
утас: 31-15-53; факс: 32-95-34, E-mail: Mswf@mongolnet.mn

2004.08.06 № 3/780
танай _____-ны № _____-г

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Улсын Их хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны хүсэлтээр "Тахир дутуу иргэдийн мэргэжлийн сургалт, сэргээн засалтын үндэсний төвийн 2004 оны төсвийн хөрөнгийн зарцуулалт, санхүүгийн тайлагнал"-д танай газраас хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа.

Аудитын тайлангаас гарсан дүгнэлт зөвлөмжийг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд эдгээр зөвлөмжийн дагуу тодорхой ажил зохион байгуулж биелэлтийг эргэн тайлагнах болно.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА  О.БАЙГАЛМАА

85 0002

Холбогдох байгууллагын санал

Тахир дутуу
иргэдийн
мэргэжлийн
сургалт, сэргээн
засалтын
үндэсний төвийн
санал

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН ЯАМ ТАХИР ДУТУУ ИРГЭДИЙН МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, СЭРГЭЭН ЗАСАЛТЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

200.5-оны.4-дугаар
сарын.7-ны өдөр

Дугаар.98

Улаанбаатар хот
Ш/х 20-364 Утас/факс 976-11-352423
E-mail: rehabcenter@maginet.mn

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Санал өгөх тухай

Танай газраас тус төвийн үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлантай танилцлаа. Үндэсний мэргэжлийн төв байгууллага бидний ажилд үнэлгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгч, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн явдалд талархаж байгаагаа илэрхийлэе.

Аудитын тайлангийн дүгнэлтэнд дүн шинжилгээ хийх, зөвлөмжөөр тус төвд өгөгдөж байгаа үүргийг хэрэгжүүлэх, цаашид үйл ажиллагааныхаа хүрээг өргөтгөх, байгууллагын нээлттэй байдлыг нэмэгдүүлэх, мэргэжлийн байгууллагуудын оролцоо дэмжлэгийг зохих ёсоор ашиглах, хамтран ажиллах талаар анхаарч ажиллах болно.

Төсвийн байгууллагуудын ажиллагчдын нийгмийн асуудалд туслалцаа үзүүлэх, төрийн өмчийн ашиглалтыг нэмэгдүүлэх зорилгоор байгууллага өөрийн нөөц бололцоо, мэргэжлийн боловсон хүчний чадавхи, материаллаг баазаа ашиглан нэмэгдэл бүтээгдэхүүн үйлдвэрлэн төлөвлөгөөнөөс давуулан олсон орлогынхоо 80 хүртэлх хувийг ажиллагчдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэх, цалин урамшлыг нэмэгдүүлэх арга хэмжээнд зарцуулах боломжийг шийдвэрлэж өгөх талаар холбогдох байгууллагад санал болгож өгөхийг хүсье.



ЗАХИРАЛ

Д.Б.ЯМБАА

Зөвлөмж

Зөвлөмж

Тахир дутуу иргэдийн мэргэжлийн сургалт сэргээн засалтын үндэсний төвийн 2004 оны үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн доорхи арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дараахь албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

1. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ц.Баярсайханд:
 - Протез, ортопедийн үйлдвэрийн техник, технологийг шинэчлэх, сэргээн засах эмчилгээний байрны нөхцлийг сайжруулах арга хэмжээ авах,
 - Тахир дутуу иргэдийг дэмжих үйл ажиллагааг гадны байгууллагын төсөл, хөтөлбөрт хамруулах ажлыг нэмэгдүүлэх.
2. Тахир дутуу иргэдийн мэргэжлийн сургалт, сэргээн засалтын үндэсний төвийн захирал Д.Бямбаад:
 - Тахир дутуу иргэдэд үзүүлэх үйлчилгээний хамрах хүрээг нэмэгдүүлэх,
 - “Тэгш дүүрэн” хөтөлбөрийн зээлийн эргэлтийн сангаас мэргэжлийн боловсрол эзэмшсэн төгсөгчдийн боловсруулсан төслийг санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллах,
 - Хийгдсэн шалгалтын үр нөлөөг дээшлүүлэхэд хариуцсан яам, мэргэжлийн байгууллагын оролцоо, дэмжлэгтэйгээр хугацаанд нь хэрэгжүүлж ажиллах.

Аудитын тайлантай холбогдуулан нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 263533 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.

Хэлтсийн дарга

О.Мэндбаяр